2025 оны 4-р сарын 24

БАЯНЗҮРХ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО ХАМГИЙН ИХ БАЙНА



2025 оны 1 дүгээр улирлын байдлаар зам тээврийн ослын улмаас 164 хүүхэд зам тээврийн осолд өртсөнөөс Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд хамгийн их бүртгэгдсэн байна.

Тодруулбал, Баянзүрх дүүрэгт 41,

- Хан-Уул дүүрэгт 39,


- Баянгол дүүрэгт 32,

- Сүхбаатар дүүрэгт 20,

- Чингэлтэй дүүрэгт 18,

- Сонгинохайрхан дүүрэгт 14 хүүхэд осолд өртжээ.

Дээрх 164 хүүхдийн 131 нь явганаар, 17 нь тээврийн хэрэгслээр зорчиж байх үедээ, 1 нь чаргаар гулгаж байхдаа, 15 нь унадаг дугуй болон цахилгаан дугуйгаар замын хөдөлгөөнд оролцож явах үедээ зам тээврийн осолд өртсөн байна.



> · *Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн 27.2 дугаар зүйлд заасан "замын хөдөлгөөнд оролцогчоос бусад иргэн, хуулийн этгээд дараах үүргийг хүлээнэ: 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд явганаар оролцуулахгүй байх." гэсэн иргэний үүргээ хариуцлагатай биелүүлэх;*
>
> · *Хүүхдүүддээ замын хөдөлгөөнд дүрмийн дагуу зөв, соёлтой, аюулгүй байдлаа ханган оролцож байх ойлголт, мэдлэгийг өгөх, дадлыг эзэмшүүлэхэд онцгой анхаарах;*
>
> · *Эцэг, эхчүүд хүүхдээ зам, замын хөдөлгөөний эрсдэл бүхий газарт явганаар зорчих, тоглох, унадаг дугуйтай явахаас нь сэргийлж, байнга анхаарал хандуулахыг зөвлөж байна.*

Эх сурвалж: https://trpo.prosecutor.mn/post/3265